



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/26/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Балжинням

Утас: 99495309

цахим хаяг: D.Baljinyam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	3
<b>Аудитын гол асуудал</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	11
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	11
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	11
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	11
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	11
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	12
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	12
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	12
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	12
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	13
<b>4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн</b> .....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	13
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

---

МЯНГАН УГАЛЗАТЫН НУРУУНЫ  
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА  
Т.ЛХАГВАДОРЖ ТАНАА

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт онцлох ажил гүйлгээ байхгүй болно.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 94.5 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>43,572,255.59</u></b>	<b><u>72,804,026.30</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	377,786.30	377,786.30
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	377,786.30	377,786.30
3351	Байгууллагаас авах авлага	377,786.30	377,786.30
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	43,194,469.29	72,426,240.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	43,194,469.29	72,426,240.00
35470	Бусад хангамжийн материал	43,125,969.29	72,426,240.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>154,983,786.22</u></b>	<b><u>131,553,224.04</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	154,983,786.22	131,553,224.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	124,653,786.30	101,333,224.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	49,134,501.12	49,134,501.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,452,243.84	-5,936,325.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,657,000.00	47,657,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,894,000.00	-25,788,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,608,678.47	77,608,678.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,995,939.28	-52,458,793.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,520,331.39	13,520,331.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,924,541.56	-9,070,834.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-3,333,333.36
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	30,329,999.92	30,219,999.88
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-220,000.08	-330,000.12
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>198,556,041.81</u></b>	<b><u>204,357,250.34</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>198,556,041.81</u></b>	<b><u>204,357,250.34</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	198,556,041.81	204,357,250.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	47,571,030.00	47,571,030.00
51101	Өмч: - төрийн	47,571,030.00	47,571,030.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	142,805,259.69	148,606,468.22
51210	Өмнөх үеийн үр дүн	142,805,259.69	142,805,259.69
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	5,801,208.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,179,752.12	8,179,752.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>198,556,041.81</u></b>	<b><u>204,357,250.34</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>252,663,100.00</b>	<b>288,681,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,140,800.00</b>	<b>50,968,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,140,800.00	50,968,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,140,800.00	50,968,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	254,000.00	4,120,200.00

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,886,800.00	46,847,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>234,522,300.00</b>	<b>237,713,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	234,522,300.00	237,713,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	234,522,300.00	237,713,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>258,777,976.80</b>	<b>268,669,132.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>258,777,976.80</b>	<b>268,669,132.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	250,416,666.57	255,204,273.66
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	122,805,281.77	165,908,940.48
210101	Үндсэн цалин	95,959,781.77	134,884,434.09
210102	Нэмэгдэл	24,101,200.00	28,315,006.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,744,300.00	2,709,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,102,300.00	22,389,700.00
210201	Тэтгэврийн даатгал	12,034,900.00	15,224,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,266,800.00	1,791,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,500.00	1,433,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,400.00	358,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,533,700.00	3,582,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,071,610.00	4,656,446.00
210301	Гэрэл, цахилгаан	1,783,500.00	959,936.00
210302	Түлш, халаалт	2,958,210.00	2,629,010.00
210303	Цэвэр, бохир ус	1,329,900.00	1,067,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,480,100.00	13,460,800.00
210401	Бичиг хэрэг	427,600.00	271,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,424,100.00	11,873,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,386,000.00	1,112,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	242,400.00	203,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	174,200.00	146,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,200.00	146,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	340,600.00	277,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	99,600.00	83,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,000.00	194,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,219,800.00	914,800.00
210702	Дотоод албан томилолт	2,219,800.00	914,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	60,709,798.00	23,576,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,947,138.00	23,014,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	103,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	248,475.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	210,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	26,512,976.80	23,873,362.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	526,800.00	442,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,986,176.80	23,430,562.18
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,361,310.23	13,464,858.52
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	8,361,310.23	13,464,858.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,361,310.23	13,464,858.52
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-6,114,876.80</b>	<b>20,012,567.82</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	2,160,000.00	14,211,359.29
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,160,000.00	14,211,359.29
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-2,160,000.00	-14,211,359.29
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-8,274,876.80</b>	<b>5,801,208.53</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>234,776,300.00</b>	<b>241,833,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>254,000.00</b>	<b>4,120,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	254,000.00	4,120,200.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	254,000.00	4,120,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	254,000.00	4,120,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>234,522,300.00</b>	<b>237,713,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	234,522,300.00	237,713,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	234,522,300.00	237,713,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>234,776,300.00</b>	<b>241,833,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>234,776,300.00</b>	<b>241,833,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>226,414,989.77</b>	<b>228,369,041.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	122,805,281.77	165,908,940.48
210101	Үндсэн цалин	95,959,781.77	134,884,434.09
210102	Нэмэгдэл	24,101,200.00	28,315,006.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,744,300.00	2,709,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,102,300.00	22,389,700.00
210201	Тэтгэврийн даатгал	12,034,900.00	15,224,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,266,800.00	1,791,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,500.00	1,433,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,400.00	358,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,533,700.00	3,582,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,071,610.00	4,656,446.00
210301	Гэрэл, цахилгаан	1,783,500.00	959,936.00
210302	Түлш, халаалт	2,958,210.00	2,629,010.00
210303	Цэвэр, бохир ус	1,329,900.00	1,067,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,548,600.00	13,392,300.00
210401	Бичиг хэрэг	496,100.00	202,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,424,100.00	11,873,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,386,000.00	1,112,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	242,400.00	203,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	174,200.00	146,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,200.00	146,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	340,600.00	277,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	99,600.00	83,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,000.00	194,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,219,800.00	914,800.00
210702	Дотоод албан томилолт	2,219,800.00	914,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	62,625,798.00	20,239,955.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,863,138.00	19,677,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	103,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	248,475.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	210,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	526,800.00	442,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	526,800.00	442,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,361,310.23</b>	<b>13,464,858.52</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	8,361,310.23	13,464,858.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,361,310.23	13,464,858.52

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,571,030.00	8,179,752.12	142,805,259.69	198,556,041.81
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,571,030.00	8,179,752.12	142,805,259.69	198,556,041.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	47,571,030.00	8,179,752.12	142,805,259.69	198,556,041.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,801,208.53	5,801,208.53
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,571,030.00	8,179,752.12	148,606,468.22	204,357,250.34

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	243,080,700.00	228,369,042.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	243,080,700.00	228,369,042.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	243,080,700.00	228,369,042.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	126,683,600.00	122,805,281.77
210101	Үндсэн цалин	99,838,100.00	95,959,781.77
210102	Нэмэгдэл	24,101,200.00	24,101,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,744,300.00	2,744,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,102,300.00	17,102,300.00
210201	Тэтгэврийн даатгал	12,034,900.00	12,034,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,266,800.00	1,266,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,500.00	1,013,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,400.00	253,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,533,700.00	2,533,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,373,900.00	6,071,610.00
210301	Гэрэл, цахилгаан	1,783,500.00	1,783,500.00
210302	Түлш, халаалт	4,260,500.00	2,958,210.00
210303	Цэвэр, бохир ус	1,329,900.00	1,329,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,916,800.00	14,548,600.00
210401	Бичиг хэрэг	496,100.00	496,100.00
210402	Тээвэр, шатахуун	14,792,300.00	12,424,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,386,000.00	1,386,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	242,400.00	242,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	174,200.00	174,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,200.00	174,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	340,600.00	340,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	99,600.00	99,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,000.00	241,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,219,800.00	2,219,800.00
210702	Дотоод албан томилолт	2,219,800.00	2,219,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	72,438,800.00	62,625,798.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,634,000.00	61,863,138.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	148,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	297,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,500.00	57,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>526800.00</b>	<b>526800.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	526,800.00	526,800.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>243,080,700.00</b>	<b>228,369,042.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	237,713,700.00	224,248,841.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>5,3670000.0</b>	<b>4,120,200.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,67,000.00	4,120,200.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12.00</b>	<b>12.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>12.00</b>	<b>12.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	03.00	03.00

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>150,000.00</b>
<b>26</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>150,000.00</b>
<b>261</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	150,000.00
<b>2610</b>	<b>Татан төвлөрүүлсэн</b>	0.00	150,000.00
261090	Татан төвлөрүүлсэн	0.00	150,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	150,000.00
131103	Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.00	150,000.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь салбарын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар Алтайн аргаль хонины тогтвортой өсөж үржих нөхцөлийг ханган, нутгийн иргэдийн оролцоотойгоор байгалийн нөөц баялгийг хамгаалах зохистой ашиглах менежментийг бий болгох зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Байгууллагын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар нийт батлагдсан орон тоо 12, гүйцэтгэлээр 12 албан хаагч ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Байгаль орчны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо тооллого хийж, хяналт тавин ажилласан байна.

БОАЖ яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58.0 сая төгрөгөөр буюу 29 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	377.7	377.7	-
Бараа материал	43125.9	72426.2	29300.0
Үндсэн хөрөнгө	154983.7	131553.2	23430.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>198556.0</b>	<b>204357.2</b>	<b>58012.0</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>198556.0</b>	<b>204357.2</b>	<b>58012.0</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>198556.0</b>	<b>204357.2</b>	<b>58012.0</b>

Дээрх хүснэгтээс харахад Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58012.0 мянган төгрөгөөр өссөнд материаллаг нөлөө үзүүлж байгаа данс нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг бараа материалын үнийн өсөлт, урсгал засвар хийгдэх шаардлагын улмаас өмнөх оны гүйцэтгэл дээр 24.5 сая төгрөгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлж улсын төсвөөс 268.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 24.5 сая төгрөгөөр бууруулж 243.0 сая төгрөгөөр баталсан нь улсын төсвөөс санхүүжих санхүүжилтийг өмнөх оны дүнгээс 3.3 сая төгрөгөөр бууруулж, өөрийн орлогын төлөвлөгөөг 3.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэсэн баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлангийн хугацаанд тухайн байгууллага нь улсын төсвөөс 237.7 сая төгрөгийн, өөрийн орлогоор 4.1 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлж нийт 241.8 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 228.4 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 13.4 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд тусгай хамгаалалттай газрын хураамжийн 150.0 мянган төгрөгийн орлого орж, гүйцэтгэлээр 150.0 мянган төгрөгийг харьяа дээд газрын дансанд татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 02 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14/06 албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 272.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд заасан албан томилолт, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэл, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлийн 15.2 -ын зарим заалтууд хамаарахгүй байна.

Тус хуулийн 15.2 зааснаар байр ашиглалтай холбоотой зардал, цалин хөлсийг гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгосноор батлагдсан төсвийг 13.4 сая төгрөгөөр хэмнэж дээд шатны байгууллагын дансанд татан төвлөрүүлсэн байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тухайн байгууллагад тайлант онд зарцуулсан шатахууны жолоочийн замын тооцооны хуудасны тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргаагүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, тооллого тооцоог цаг тухайд хийгээгүй, Засгийн газрын тогтоолыг хэрэгжилтийг ханган ажиллаагүйтэй холбоотой 15.7 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөнийг тайлант онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	4	15700.0	4	15700.0	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>15700.0</b>	<b>4</b>	<b>15700.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийх алдаа<sup>1</sup> илрээгүй болно.

Харин цаашид сайжруулах шаардлагатай 1.2 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэн тул зөрчлийг арилгуулах 1 зөвлөмж өглөө.

#### 5.4 Зөвлөмж

##### 5.4.1 Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөтэй холбоотой асуудал

**5.4.1 Илрүүлэлт:** Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1.2 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн зөрчил дутагдал илэрлээ.

**5.4.2. Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1.2 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн	1	1246.8	-	-	-	-	1	1246.8
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1246.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1246.8</b>

### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

### ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Д.БАЛЖИННЯМ